



**БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 13-ны өдөр

Дугаар 52

Булган сум

Г Төрийн шагналд уламжлах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам”-ын 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Булган аймгийн Булган сумын 1 дүгээр багийн иргэн Очирсүрэн овогтой Мэдэхгүйг “Монгол улсын Гавъяат мал зүйч” цолоор шагнуулахаар, Булган сумын 4 дүгээр багийн иргэн Ёндонгийн Нэргүйг “Хөдөлмөрийн гавьяаны улаан туг”-ийн одонгоор, Раднаагийн Ганболд, Доржсүрэнгийн Бямбажав нарыг “Алтан гадас” одонгоор, Агваангомбосүрэнгийн Буянхүүг “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнуулахаар багийн Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдээс ирүүлсэн саналыг тус тус дэмжсүгэй.

2. Төрийн шагналын тодорхойлолт, холбогдох материалыг аймгийн Засаг даргын Тамгын газарт уламжлахыг сумын Засаг дарга П.Нөхөрлөлбаярт даалгасугай.

ДАРГА



Б.ГАНЗОРИГ